



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 11 сарын 28 өдөр

Дугаар 586

Улаанбаатар хот

Хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Дотоод хэргийн их сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 8,800,000.00 (найман сая найман зуун мянга) төгрөгийн балансын үнэ, 4,399,999.99 (дөрвөн сая гурван зуун ерэн есөн мянга есөн зуун ерэн есөн төгрөг ерэн есөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг Онцгой байдлын ерөнхий газарт балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Дотоод хэргийн их сургуулийн захирал, бригадын генерал П.Батбаатар, Онцгой байдлын ерөнхий газрын Санхүү, ар талын газрын дарга, хурандаа Я.Гантөмөр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

133602614
27-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 11 дүгээр сарын 18 ны өдрийн
586 дугаар тогтоолын хавсралт

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ОНЦГОЙ БАЙДЛЫН ӨРӨНХИЙ ГАЗАРТ
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Хэм жих нэгж	Ашиглалтад орсон огноо	Тоо шир хэг	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Ухаалаг дэлгэц (ХQ-T85 загварын 85 инч, дугуйтай хөлтэй)	8,800,000.00	ш	2022.06.02	1	8,800,000.00	4,399,999.99	4,400,000.01
	Нийт дүн					8,800,000.00 (найман сая найман зуун мянган)	4,399,999.99 (дөрвөн сая гурван зуун ерэн есөн мянга есөн зуун ерэн есөн төгрөг ерэн есөн мөнгө)	4,400,000.01 (дөрвөн сая дөрвөн зуун мянган төгрөг нэг мөнгө)